

Санваарын тангараг, гэрээний талаарх ойлголтоо гүнзгийрүүл

Биеэ шинэчлэхийн тулд Сүнсээр ариусгагдсан (33-р шүлгийг үзнэ үү)

Тэргүүн зөвлөлийн ерөнхийлөгч Хэнри Б.Айринг Тэнгэрлэг Эцэгийн амлалтын талаар ийн ярьсан.



Би энэ амлалтыг өөрийнхөө болон бусдын амьдралд биелэхийг харсан. Миний нэг найз номлолын ерөнхийлөгчөөр үйлчилсэн юм. Тэр үйлчилж байхдаа орой бүр, маргаашийг яаж шуухан давж гарах эсэхээ гайхширан бодсоор орондоо арайхийн ордог байснаа надад хэлсэн юм. Харин маргааш өглөө нь түүний эрч хүч, урам зориг сэргэсэн байдаг байв. Та нар үүнийг Их Эзэн Есүс Христийг болон сэргээгдсэн сайн мэдээг гэрчлэхээр зогсох бүрд шинэчлэгддэг юм шиг санагддаг ахимаг настай бошиглогчдын амьдралаас харж байсан. Энэ нь санваарын үйлчлэлдээ итгэл тээн урагшилдаг хүмүүст зориулсан амлалт юм. (Henry B. Eyring, "Faith and the Oath and Covenant of the Priesthood," *Liahona*, May 2008, 62)

Аароны болон Мелкизедек санваарыг хүртэхдээ итгэлтэй бай (33-р шүлгийг үзнэ үү)

“Энэ хоёр санваарыг хүртэхэд” (Сургаал ба Гэрээ 84:33) итгэлтэй байхад Аароны болон Мелкизедек санваарын ёслолуудыг хүртэж, холбогдох гэрээг итгэлтэйгээр сахиснаар ирэх хүч чадал, адислалуудыг олж авах багтдаг. Бошиглогч Иосеф Смит хүн “бүх зарлигийг сахиж, Их Эзэний өргөөний бүх ёслолыг дуулгавартай дагаснаар” санваарын бүрэн байдлыг олж авдаг гэж заасан (*Сумийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит* [2007], 474).

Эрэгтэйчүүдийн хувьд энэ нь тэдэнд санваар хүртээх, санваарын албан тушаалд томилогдсон байх зэрэг нь орно.

Дуудлагаа эрхэмлэн биелүүл (33-р шүлэг)

Сургаал ба Гэрээ 58:27–28; 107:99–100

Дуудлага хүлээн авч, Их Эзэний авралын ажилд оролцох боломж

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ерөнхийлөгч М.Рассэлл Баллард ийн заасан.



Бид дуудлагаа эрхэмлэн биелүүлэхээр хөдөлмөрлөхдөө үйлчилдэг хүмүүстээ хамгийн сайн туслах арга замаар асуудлыг шийдвэрлэх Сүнсний өдөөлтийг эрэлхийлэх ёстой. Бидэнд байдаг удирдамж бүхий гарын авлагаа бид дагаж мөрдөх ёстой. Гэхдээ энэ хүрээнд бодох, бүтээлч байх, хувь хүний авьяасыг ашиглах зэрэг асар их боломж бий. Дуудлагаа эрхэмлэн биелүүлэх удирдамж нь үүнийг гоёж, төвөгтэй болгох зарлиг биш юм. Шинэчилнэ гэдэг нь заавал баяжуулна гэсэн үг биш, харин ихэнхдээ энэ нь хялбарчилна гэсэн үг юм. (M. Russell Ballard, "O Be Wise," *Liahona*, Nov. 2006, 19)

Тэнгэрлэг Эцэгт байгаа бүхэн (38-р шүлгийг үзнэ үү)

Сургаал ба Гэрээ 76:55–60; 81:6